



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 09 сарын 17 өдөр

дугаар А/356

Баруун-Урт

Дэд зөвлөл байгуулах тухай

“Монгол Улсын үндсэн хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1, “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 42 дугаар зүйлийн 42.3, “Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан эзэмшүүлэх үүрэг бүхий аймгийн Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар батална гэж.

Хоёр. Дэд зөвлөлийг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Дэд зөвлөлийн дарга /Д.Хосбаяр/- т даалгасугай.


Гурав. Нутаг дэвсгэрт нь ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул олборлолтын үйл ажиллагаа явуулдаг сумдад Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолын 11.3, 11.4, 11.5 дахь заалтуудыг хэрэгжүүлэх дэд зөвлөл /олон талт зөвлөл/-ийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулж холбогдох тайланг аймгийн дэд зөвлөлд жил бүрийн 03 дугаар сарын 01-ний дотор ирүүлж хэрэгжилтийг хангуулж байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ захирамжийг ил тодоор холбогдуулан “Салбар зөвлөл байгуулах тухай” Засаг даргын 2009 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 99 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.БАТСУУРЬ

Аймгийн Засаг даргын 2013 оны..... дүгээр  
сарын.....-ны өдрийн.....дугаар захирамжийн  
хавсралт



Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг  
хэрэгжүүлэх аймгийн дэд зөвлөлийн бүрэлдэхүүн

Дэд зөвлөлийн дарга	Д.Хосбаяр ✓	-Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд	Х.Энхтүвшин	-Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
	Х.Төгсбаяр ✓	- Байгаль орчны газрын дарга
	М.Эрдэнэ	-Татварын хэлтсийн дарга
	Д.Ариунжаргал	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Ш.Нямхүү ✓	-Байгаль орчны газрын мэргэжилтэн
	Г.Ариунболд ✓	-Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч
	С.Амартайван ✓	-Эрдэнэцагаан сумын Засаг дарга
	Л.Бор	-Их бага баян шарга Төрийн бус байгууллагын тэргүүн
	Г.Эр	-Монголын байгаль орчны эргэцүүлэх үйлдвэрлэлийн удирдах зөвлөлийн гишүүн
		-Сүхбаатар аймгийн Байгаль орчны иргэний салбар зөвлөлийн гишүүн 1
	-Эрдэнэцагаан, Мөнххаан, Сүхбаатар, Түвшинширээ, Онгон, Уулбаян сумдын олон талт зөвлөлийн ахлагч нар	
	-Тус аймагт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөөлөл болж Цайрт минерал, Энгүй тал, Баян-Эрч, Резевоирмоли монголын Монголжююаньли ХХКомпаниадын захирал	
	-Тус аймагт цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөөлөл болж Тунган сайхан, Кожеговь ХХКомпаний захирал	
	-Тус аймагт газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн төлөөлөл болж Алексро, Вольф петорлиум ХХК-ний захирал	
Нарийн бичгийн дарга	М.Гэрэлт-Од ✓	-Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн